

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2026/015/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Цэцэгмаа
Утас: 99041524 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 15 № 116

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус сумд ашиглалтад орсон 420 хүний суудалтай 4,420,181.1 мянган төгрөгийн өртөгтэй спорт цогцолборын барилгын 1 дүгээр давхарт сумын Засаг даргын Тамгын газар үйл ажиллагаагаа явуулж байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд гүйцэтгэлээр 1,239,224.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бусад асуудал

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 10 зорилт, 113 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлснээр тайлагнасан байна.

822511000350

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	430,129,476.00	440,513,126.00
33	АВЛАГА	23,000,000.00	14,600,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	23,000,000.00	14,600,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	397,129,476.00	415,913,126.00
351	Түүхий эд материал	53,000,000.00	69,180,000.00
35110	Тусгай зориулалттай материал	53,000,000.00	69,180,000.00
354	Хангамжийн материал	117,264,475.00	119,868,125.00
35410	Бичиг хэргийн материал	835,800.00	945,800.00
35420	Аж ахуйн материал	64,269,600.00	66,703,850.00
35430	Сэлбэг хэрэгсэл	12,679,500.00	12,738,900.00
35450	Барилгын засварын материал	17,560,942.00	17,560,942.00
35470	Бусад хангамжийн материал	21,918,633.00	21,918,633.00
35600	Мал амьтад	226,865,001.00	226,865,001.00
36	НӨӨЦИЙН БАРАА	10,000,000.00	10,000,000.00
36300	Тэжээлийн нөөц	10,000,000.00	10,000,000.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,809,958,106.80	2,502,612,090.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,809,958,106.80	2,502,612,090.65
392	Биет хөрөнгө	1,569,584,106.80	2,262,238,090.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	989,112,888.88	1,533,612,888.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(557,660,124.79)	(632,853,019.67)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	264,676,709.00	492,681,909.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(164,965,534.67)	(119,832,719.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,593,353.80	73,803,415.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,195,773.17)	(48,457,559.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,350,820.00	37,747,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,772,830.21)	(25,028,876.97)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	80,000,000.00	80,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,309,075,542.00	1,371,278,142.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(400,630,944.04)	(500,713,909.34)
393	Биет бус хөрөнгө	240,374,000.00	240,374,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	240,374,000.00	240,374,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,240,087,582.80</u>	<u>2,943,125,216.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	37,210,608.81	79,562,842.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,210,608.81	79,562,842.00
413	Өглөг	37,210,608.81	79,562,842.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	24,140,508.81	5,811,532.00
4136	Бусад өглөг	13,070,100.00	73,751,310.00
41361	Байгууллагад төлөх өглөг	13,070,100.00	72,836,310.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	915,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,202,876,973.99	2,863,562,374.65
51	Засгийн газрын хувь оролцоо	2,202,876,973.99	2,863,562,374.65
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	327,928,674.84	327,928,674.84
512	Хуримтлагдсан үр дүн	1,794,756,035.17	2,455,441,435.83
51210	Өмнөх үеийн үр дүн	1,876,250,334.54	1,794,756,035.17
51220	Тайлант үеийн үр дүн	(81,494,299.37)	660,685,400.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,192,263.98	80,192,263.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,240,087,582.80</u>	<u>2,943,125,216.65</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,643,683,623.00	2,196,101,612.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	119,671,300.00	936,727,061.93
120	Нийтлэг татварын бус орлого	119,671,300.00	936,727,061.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	119,671,300.00	936,727,061.93
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	104,000,000.00	930,547,061.93
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	15,671,300.00	6,180,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,524,012,323.00	1,259,374,551.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	337,003,323.00	20,150,151.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	337,003,323.00	15,970,151.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,180,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,187,009,000.00	1,239,224,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,187,009,000.00	1,239,224,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,725,177,922.37	1,535,416,212.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,725,177,922.37	1,535,416,212.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,660,096,480.18	1,416,212,844.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	660,992,509.00	703,051,191.00
210101	Үндсэн цалин	433,466,683.00	469,317,684.00
210102	Нэмэгдэл	195,661,216.00	233,733,507.00
210104	Урамшуулал	10,483,452.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	21,381,158.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,401,999.81	77,849,749.97
210201	Тэтгэврийн даатгал	78,001,999.81	51,797,778.95
210202	Тэтгэмжийн даатгал	6,100,000.00	6,381,728.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,050,000.00	4,789,968.76
210204	Ажилгүйдлийн даатгал	3,050,000.00	2,215,959.76
210205	Эрүүл мэндийн даатгал	12,200,000.00	12,664,314.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,455,608.81	145,827,329.86
210301	Гэрэл, цахилгаан	8,986,108.81	9,983,159.86
210302	Гүлш, халаалт	52,469,500.00	135,844,170.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,563,413.00	60,696,999.44
210401	Бичиг хэрэг	8,930,450.00	4,368,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,579,463.00	46,589,299.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,146,500.00	2,994,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,907,000.00	6,745,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,379,700.00	5,258,700.00
210604	Урсгал засвар	16,379,700.00	5,258,700.00
2107	Томилголт, зочны зардал	17,970,000.00	4,670,000.00
210702	Дотоод албан томилголт	17,970,000.00	4,670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,512,079.00	1,925,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,434,640.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	498,525.00	260,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	410,792.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	230,000.00
210807	Газрын төлбөр	2,349,762.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	771,821,170.56	416,933,674.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	530,079,630.00	175,145,096.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,749,200.00	880,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	239,992,340.56	240,908,578.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,081,442.19	119,203,367.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,461,935.00	61,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,147,935.00	12,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,500,000.00	49,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	814,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,619,507.19	58,203,367.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,619,507.19	53,310,115.78
213405	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		4,893,251.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(81,494,299.37)	660,685,400.66
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(81,494,299.37)	660,685,400.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,524,012,323.00	1,279,274,551.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,524,012,323.00	1,279,274,551.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	337,003,323.00	40,050,151.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	337,003,323.00	35,870,151.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,180,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,187,009,000.00	1,239,224,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,187,009,000.00	1,239,224,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,509,522,923.00	1,276,259,051.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,509,522,923.00	1,276,259,051.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,444,441,480.81	1,145,555,683.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,744,000.00	701,488,168.00
210101	Үндсэн цалин	429,218,174.00	454,388,218.00
210102	Нэмэгдэл	195,661,216.00	247,099,950.00
210104	Урамшуулал	10,483,452.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	21,381,158.00	-
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,510,000.00	97,741,749.78
210201	Тэтгэврийн даатгал	58,110,000.00	71,689,778.76
210202	Тэтгэмжийн даатгал	6,100,000.00	6,381,728.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,050,000.00	4,789,968.76
210204	Ажилгүйдлийн даатгал	3,050,000.00	2,215,959.76
210205	Эрүүл мэндийн даатгал	12,200,000.00	12,664,314.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,385,508.81	104,701,339.86
210301	Гэрэл, цахилгаан	8,986,108.81	9,983,159.86
210302	Түлш, халаалт	39,399,400.00	94,718,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,781,363.00	37,294,179.44
210401	Бичиг хэрэг	8,418,900.00	1,975,250.00
210402	Тээвэр, шатахуун	26,579,463.00	31,667,029.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,146,500.00	3,002,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,636,500.00	649,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,854,700.00	6,902,450.00
210604	Урсгал засвар	17,854,700.00	6,902,450.00
2107	Томилолт, зочны зардал	17,970,000.00	4,670,000.00
210702	Дотоод албан томилолт	17,970,000.00	4,670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,662,079.00	1,925,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,434,640.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	498,525.00	260,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	410,792.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	403,000.00	230,000.00
210807	Газрын төлбөр	2,349,762.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	577,533,830.00	190,832,596.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	575,784,630.00	189,952,596.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,749,200.00	880,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,081,442.19	130,703,367.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,461,935.00	61,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,147,935.00	12,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,500,000.00	49,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	814,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,619,507.19	69,703,367.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,619,507.19	53,310,115.78

Говь-Алтай аймгийн Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		16,393,251.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,489,400.00	3,015,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,489,400.00	3,015,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,489,400.00	3,015,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,489,400.00	3,015,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,489,400.00	3,015,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(14,489,400.00)	(3,015,500.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,928,674.84	80,192,263.98	1,794,756,035.17	0.00	2,202,876,973.99
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	327,928,674.84	80,192,263.98	1,794,756,035.17	0.00	2,202,876,973.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,928,674.84	80,192,263.98	1,794,756,035.17	0.00	2,202,876,973.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	660,685,400.66	0.00	660,685,400.66
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,928,674.84	80,192,263.98	2,455,441,435.83	0.00	2,863,562,374.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,284,202,400.00	1,185,914,284.22	92.3%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,284,202,400.00	1,185,914,284.22	92.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,222,202,400.00	1,124,914,284.22	92.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,820,000.00	701,488,168.00	100.0%
210101	Үндсэн цалин	363,300,000.00	454,388,218.00	125.1%
210102	Нэмэгдэл	338,520,000.00	247,099,950.00	73.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,619,400.00	97,741,749.78	77.2%
210201	Тэтгэврийн даатгал	96,888,700.00	71,689,778.76	74.0%
210202	Тэтгэмжийн даатгал	7,018,200.00	6,381,728.50	90.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,614,600.00	4,789,968.76	85.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,061,500.00	2,215,959.76	72.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	14,036,400.00	12,664,314.00	90.2%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,716,700.00	104,701,339.86	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	20,000,000.00	9,983,159.86	49.9%
210302	Түлш, халаалт	84,716,700.00	94,718,180.00	111.8%
2104	Хангамж, бараа материалын зардал	28,950,000.00	19,846,580.00	68.6%
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	1,975,250.00	39.5%
210402	Тээвэр, шатахуун	19,450,000.00	14,429,430.00	74.2%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,792,900.00	93.1%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	649,000.00	43.3%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,917,950.00	99.2%
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,917,950.00	99.2%
2107	Томилолт, зочны зардал	11,000,000.00	4,670,000.00	42.5%
210702	Дотоод албан томилолт	11,000,000.00	4,670,000.00	42.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,450,000.00	1,925,200.00	29.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,434,640.00	95.6%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	-	0.0%
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	-	0.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	260,560.00	57.9%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	230,000.00	46.0%
210807	Газрын төлбөр	2,500,000.00	-	0.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	232,646,300.00	184,623,296.58	79.4%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	231,646,300.00	183,743,296.58	79.3%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	880,000.00	88.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,000,000.00	61,000,000.00	98.4%
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,000,000.00	61,000,000.00	98.4%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,000,000.00	12,000,000.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,000,000.00	49,000,000.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-	0.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,284,202,400.00	1,185,914,284.22	92.3%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,284,202,400.00	1,185,914,284.22	92.3%
132001	Орон нутгийн төсвөөс	1,284,202,400.00	1,185,914,284.22	92.3%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	0.00

2.6 Нэмэлт төсвийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,050,151.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,050,151.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,656,899.44
2104	Хангамж, бараа материалын зардал	17,447,599.44
210402	Тээвэр, шатахуун	17,237,599.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,209,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,209,300.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,393,251.56
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	16,393,251.56
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,050,151.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,050,151.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,870,151.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,180,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 1,446,591.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

3.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 1,006,926.3 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны үр дүнг 3,074.5 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэл төсвийн хэлбэлзлээс 41,619.9 мянган төгрөгөөр зөрүүтэй.
- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ болох 101,949.1 мянган төгрөгийн 6 мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 293,021.4 мянган төгрөгийн 17 мэдээллийг аудитын хугацаанд нөхөн мэдээлүүлсэн.

Аудитаар нийт залруулагдаагүй нийт 116,518.6 мянган төгрөгийн 5 зөрчил илэрнээс Сумын сумын Засаг даргад 113,444.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын дүгнэлтэд авч үзэхээр шийдвэрлэсэн.

Бусад 3,074.6 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах 3 зөвлөмж хүргүүлж байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3.2 АЛБАН ШААРДЛАГА

Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 01/181, 04/181, 06/181, 07/181 дугаартай 152,329.4 мянган төгрөгийн албан шаардлага, 2023, 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 01/193, 02/193, 03/193, 01/98 дугаартай 68,165.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг тус тус хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цогт сумын Засаг даргын Тамгын газрын даргад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой

Нягтлан бодогч байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тооцоог бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллого хийсэн тухай бүр тооцоог бодож, үр дүнг шийдвэрлэж байх.

Хоёр. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой

Нотариатын үйлчилгээг сумын засаг даргын Тамгын газрын даргад хариуцуулж үндсэн цалингийн 10.0 хувиар тооцож 2,048.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-т "Нотариатч энэ хуульд зааснаас бусад үйлчилгээний хөлс, зардал болон шагнал, урамшуулал авахыг хориглоно", гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндэслэлгүйгээр нэмэгдэл хөлс олгож байгаа зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх.

Гурав. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Байгаль орчны бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтний орон тоонд түр томилогдсон албан хаагчид 1,026.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-т "Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээ байгуулна". Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам" -ын 2 дугаар зүйлийн 2.3-т "Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн захиргааны албан тушаалд түр ажиллаж байгаа ажилтанд нэмэгдэл цалин олгож байгаа зөрчлийг таслан зогсоох.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Цогт сумын Засаг даргын Тамгын газар	Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 1,006,926.3 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны үр дүнг 3,074.5 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	1,010,000.8	1	1,010,000.8	-	-	1	1,010,000.8	-	-	-	-
	Төсвийн гүйцэтгэл төсвийн хэлбэлзлээс 41,619.9 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	41,619.9	1	41,619.9	-	-	1	41,619.9	-	-	-	-
	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ болох 101,949.1 мянган төгрөгийн 6 мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 293,021.4 мянган төгрөгийн 17 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.	1	394,970.5	1	394,970.5	-	-	1	394,970.5	-	-	-	-
Дүн		3	1,446,591.2	3	1,446,591.2	-	-	3	1,446,591.2	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		ХХБ-д шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн Цогт сумын Засаг даргын Тамгын газар	Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 01/181, 04/181, 06/181, 07/181 дугаартай 152,329.4 мянган төгрөгийн албан шаардлага, 2023, 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 01/193, 02/193, 03/193, 01/98 дугаартай 68,165.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг тус тус хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	
	Нотариатын үйлчилгээг сумын засаг даргын Тамгын газрын даргад хариуцуулж үндсэн цалингийн 10.0 хувиар тооцож 2,048.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон.	1	2,048.2	-	-	-	-	-	1	2,048.2	-	-
	Байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтний орон тоонд түр томилогдсон албан хаагчид 1,026.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.	1	1,026.4	-	-	-	-	-	1	1,026.4	-	-
	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн зөрүүтэй, тооцоог бодоогүй байна.	1							1			
дүн		4	3,074.6	-	-	-	-	4	3,074.6	-	-	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлагдтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			